



Даатгалын нөхцөл

Та даатгалын нөхцөлтэй танилцана уу

ДААТГАЛЫН ХАМГААЛАЛТ

Даатгалын үндсэн эрсдэл			
1	Байгалийн эрсдэл	1.1 Үер (үерлэсэн гол, мөрөн, нуур гатлах үед хамаарахгүй);	✓
		1.2 Цасан болон шороон шуурга (нэг удаагийн тохиолдолд олгох нөхөн төлбөрийн дээд дүн);	30.0 сая төгрөг хүртэл
		1.3 Газар хөдлөлт;	✓
		1.4 Хөрсний нуралт, гулсалт, цөмрөлт;	
2	Галын эрсдэл	2.1 Даатгалын зүйлээс хамааралгүй гадны нөлөөллөөс үүдсэн гал түймэр болон тэсрэлт, дэлбэрэлт;	✓
3	Зам тээврийн хөдөлгөөний үеийн эрсдэл	3.1 Мөргөлдөх, шүргэлдэх;	
		3.2 Онхолдох;	✓
		3.3 Биет зүйлд өртөх;	
4	Зогсоолд байрлуулах болон зогсоолоос хөдлөх үеийн эрсдэл	4.1 Биет зүйл мөргөх, шүргэх;	
		4.2 Мөргүүлэх, шүргүүлэх;	✓
		4.3 Биет зүйлд өртөх;	
5	Шилний эрсдэл (гэрээний хугацаанд 1 удаа)	5.1 Чулуу үсрэх, биет зүйл дээрээс унах, шувуу, амьтан мөргөх;	✓
6	Жолоо шилжүүлэх үеийн эрсдэл	6.1 Жолоодох эрх бүхий жолоочид жолоо шилжүүлсэн үед энэ гэрээнд заасан эрсдэл учрах;	✓
Даатгалын нэмэлт эрсдэл			
7	Зогсоолд байх үеийн эрсдэл	7.1 Биет зүйлд өртөх;	
		7.2 Мөргүүлэх, шүргүүлэх;	
		7.3 Сантехникийн гэмтлийн улмаас үүссэн;	✓
		7.4 Гуравдагч этгээдийн учруулах;	
8	Толины хулгай (гэрээний хугацаанд 2 толь тус бүр 1 удаа);		✓
9	Дугуйнаас үүдэлтэй даатгалын гэрээнд заасан эрсдэл учрах;		✓
10	Бүрэн болон хэсэгчилсэн хулгай (дугуй, толь, яндангийн хулгай хамаарахгүй);		✓
11	Жолоочийн гэнэтийн ослын хамгаалалт (Энэ гэрээнд заасан эрсдэлийн улмаас жолоочийн эрүүл мэнд хохирсон бол эмнэлэг, эмчилгээний зардлыг хамаарах үнийн дүн хүртэл нөхөн төлнө);		1,000,000 төгрөг хүртэл
12	Дугуйнд учрах хохирол (гэрээнд заасан эрсдэлийн улмаас);		✓
Нэмэлт үйлчилгээ			
1	Онлайн даатгалын бүтээгдэхүүн, нөхөн төлбөрийн үйлчилгээ		✓
2	Хохирол үнэлгээний зардал		250,000 төгрөг хүртэл
3	Ослын дараах нэг удаагийн гадна угаалга (гэрээний хугацаанд 1 удаа)		✓
4	Засварын газар хүртэл чирч тээвэрлэх зардал (Улаанбаатар хот дотор)		✓
ДААТГУУЛАГЧИЙН ХАРИУЦАХ ХЭСЭГ (Даатгалын тохиолдол бүрд)			0%
ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХУВЬ:			2.5%

ГЭРЭЭГЭЭР ХАМГААЛАГДААГҮЙ НӨХЦӨЛ

Жолоодох эрхгүй этгээд тээврийн хэрэгслийг ашиглаж, хэрэглэх, жолоодох үед учирсан хохирол;

- Жолооч эм, тариа хэтрүүлэн хэрэглэсэн, согтууруулах ундаа, мансууруулах эсвэл сэргээх үйлчилгээтэй эм, тариа, бодис хэрэглэсэн, хэт ядарсан, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй үедээ жолоо барьсан;
- Замын хөдөлгөөний дүрэмд заасан хориглосон агуулга бүхий дараах заалтуудыг зөрчсөнөөс үүдсэн хохирол. Үүнд:
 - Улаан гэрэл дохиогоор хөдөлгөөнөө үргэлжлүүлсэн;
 - Буцаж эргэх үйлдлийг хориглосон газар, эсвэл буцаж эргэхийг хориглосон тохиолдолд буцаж эргэсэн;
 - Гүйцэж түрүүлэх үйлдлийг хориглосон газар эсвэл гүйцэж түрүүлэхийг хориглосон тохиолдолд гүйцэж түрүүлсэн, урсгал сөрж явсан;
 - Төмөр замын гармаар нэвтрэх хөдөлгөөнийг хориглосон заалтыг зөрчсөн.

САНАМЖ: Даатгалын нөхөн төлбөр олгохгүй байх нөхцөлүүдийг даатгалын гэрээнээс харна уу.

Нөхцөл	Даатгалын хураамж /төлбөр/ төлөх нөхцөл	
	Бүтэн төлөлт	4 хувааж төлөх
Төлбөр төлөх давтамж	1 удаа	Сар бүр (1 удаа)
Гэрээ баталгаажих нөхцөл	Төлбөр бүтэн төлөлт	Эхний төлбөр төлөх үед

ДААТГАЛЫН ТОХИОЛДОЛ БИЙ БОЛСОН ҮЕД

Даатгагчид 1800-1889 утсанд болон холбогдох эрх бүхий байгууллагад тухайн үйл явдлын талаар хоёрдмол утга санаагүй, дэлгэрэнгүй, нэн даруй мэдэгдэх болон учирсан хохирлыг баримтжуулах, даатгалын тохиолдлоос бий болох үр дагавар, хохирлыг бууруулах буюу нэмэгдэхийг зогсоох, давтан гаргахгүй байх боломжит бүхий л арга хэмжээг авах. Ослын үеийн болон хохирлыг нотлох шаардлага хангахуйц 4-өөс олон тооны хувь фото зураг, видео бичлэг хийн claimteam@tengerinsurance.mn хаягаар нөхөн төлбөрийн материалыг ирүүлнэ.